

ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ ХУРЛЫГ НИЙТ 10 УДАА ХУРАЛДУУЛЖ 49 БАЙГУУЛЛАГЫН АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭН ШИЙДВЭРЛЭЛЭЭ. ҮҮНД СУНГАЛТ 7, ЭРХ СЭРГЭЭЛГЭСЭН 2, ТҮДГЭЛЗҮҮЛСЭН 7, ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН 8, ХАЯГИЙН ШИЛЖИЛТ 5, ТӨСӨЛ 12, ШИНЭЭР 11 БАЙГУУЛЛАГАД ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОСОН.

-АЖЛЫН БАЙРАНД 3-5 МЭРГЭЖИЛТНИЙ БҮРЭЛДЭХҮҮНТЭЙ БАГ БАТЛАГДСАН УДИРДАМЖИЙН ДАГУУ 11 УДААГИЙН ҮНЭЛГЭЭГ ХИЙЖ, ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХУРЛААР ДҮГНЭЛТИЙГ ХЭЛЭЛЦҮҮЛЖ ШИЙДВЭРЛҮҮЛСЭН.

-ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛИЙН ХҮРЭЭНД НИЙТ 72 ЭМИЙН САНД МАНСУУРУУЛАХ, СЭТГЭЦ НӨЛӨӨТ ЭМИЙН ХЯНАЛТ, 13 ЭРСДЭЛ ӨНДӨРТЭЙ ЭМИЙН САНД ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ХЯНАЛТ ҮНЭЛГЭЭГ ХИЙЖ, ЭМ, БИОБЭЛДМЭЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧИД 5 ЗӨРЧИЛ ШАЛГУУЛАХААР ШИЛЖҮҮЛЖ, 2 ЭМИЙН САНГИЙН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛГОСОН.

-ДЭЭРХ ЭМИЙН САНГУУДАД 2 УДААГИЙН СУРГАЛТ, МЭДЭЭЛЛИЙГ 70 ЭМЧ ЗҮЙЧ, ЭМ НАЙРУУЛАГЧ НАРТ ЗОХИОН БАЙГУУЛСАН. ЦАХИМ ХӨГЖЛИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН МЭДЭЭЛЛИЙН ДАГУУ ЗДТГ-ЫН ХЭЗХ-Т ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ТАЛААРХ 3 ЧИГЛЭЛИЙН МЭДЭЭЛЛИЙГ ГАРГАН ХҮРГҮҮЖ, МЭДЭЭЛЛИЙН НЭГДСЭН ЦАХИМ ПРОГРАМ(LICENSE)-ЫН ЦАХИМ СУРГАЛТЫГ ЗОХИОН БАЙГУУЛЖ, ЭМЯ-НД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛТЭЙ 167 БАЙГУУЛЛАГЫН МЭДЭЭЛЛИЙГ ХҮРГҮҮЛЭВ.

-ЭМЯ-НД ТУСГАЙ ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ, ЗӨВШӨӨРЛИЙН ТУХАЙ ХУУЛИНД НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХТАЙ ХОЛБООТОЙ 11 САНАЛЫГ НЭГТГЭЖ ХУГАЦААНД НЬ ХҮРГҮҮЛСЭН.

-ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ХҮРЭЭНД ХАЯГИЙН ШИЛЖИЛТТЭЙ ХОЛБООТОЙ 2 ИРГЭНИЙ ГОМДЛЫГ ЭРҮҮЛ АХУЙН ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ХАМТ АЖЛЫН БАЙРАНД 4 УДААГИЙН ХЯНАЛТЫГ ХИЙЖ ШИЙДВЭРЛЭСЭН.